



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 10 өдөр

Дугаар А/10

Хэрлэн сум

Малын өвчний эх үүсвэрийг тогтоох
ажилд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.1 дэх заалт, аймгийн Онцгой комиссын 2023 оны 1 дүгээр сарын 09-ний өдрийн 01 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн, Дэлгэрхаан, Цэнхэрмандал, Батноров сумдад илэрсэн малын өвчний эх үүсвэр, шалтгаан нөхцөлийг шалган тогтоох ажилд шаардагдах 2,036,000 (хоёр сая гучин зургаан мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн малын гоц халдварт өвчинтэй тэмцэх зардлаас санхүүжүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2023
 оны 01 дүгээр сарын 10-ны
 дугаар захирамжийн хавсралт

ТОМИЛОЛТ, ШАТАХУУНЫ ЗАРДАЛ

Сумын нэр	Ажиллах сум	Ажиллах хүн	Нийт ажиллах хоног	Нэг хоногт олгох томилолт	Тоо хэмжээ /литр/	Нэг бүрийн үнэ	Нийт дүн
Мал эмнэлгийн газар, Цагдаагийн газар, Тагнуулын газрын хамтарсан ажлын хэсгийн томилолт	4	5	4	64000			1280000
Ажлын хэсгийн шатахуун	4				300	2520	756000
Дүн	4	5	4		300		2036000